



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.01.19 № 37-1/30
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000442



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

далз. 01.18 № ХЭТ/далз
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ⁵⁴ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000225002210

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тэмдэглэлд:

“VIII.ХЭЛЭЛЦСЭН нь: “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33.

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.01.18 № 1/315

танай _____-ны № _____-г

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу "Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151600552

А9 Файл.2025



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс. (976-51) 26 74 68, И-мэйл info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.01.18 № 04317


-ны №

-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

"Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.


Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761000114

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДӨТӨӨД
ХЭРГИЙН САЙД



Х.НЯМБААТАР

“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага
“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах болсон дараах үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад Улсын Их Хурал төрийн өмчийн талаар “төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах” бүрэн эрхтэй гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.12-т Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд хөтөлбөрийн хүрээнд “улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.”, 2.2.2-т Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийх хөтөлбөрийн хүрээнд “хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна;” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна.”, 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна...” гэсэн зорилтыг мөн дэвшүүлсэн.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудал тодорхой түлхэц өгөхийц арга хэмжээ болно.

1.2.Практик шаардлага

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө

шилжүүлэх асуудлыг судлан боловсруулж, Улсын Их Хурлын 2001 оны 91, 2002 оны 84, 93, 2004 оны 18, 2007 оны 37, 2009 оны 90, 2010 оны 73, 2018 оны 61 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлүүлж байсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогын дүнгээр төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай асуудал дараах хэрэгцээ, шаардлагын үүднээс дахин тавигдсан байна:

1.Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар төрийн зарим байгууллага, албан газар, төрийн өмчит компани шинээр барилга байгууламж барьж ашиглалтад оруулснаас хуучин барилга, хөрөнгийг ашиглахгүй болж байна. Нөгөө талаас төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, шат дамжлагагүй хүргэх, орон нутагт зайлшгүй хэрэгцээ шаардлагыг төсвийн хөрөнгөөр бүрэн нөхөх, бий болгох боломжгүй дараах нөхцөл байдал байна:

-Дорнод аймгийн Прокурорын газар тус аймгийн Цагдаагийн газрын байрны 4 дүгээр давхрыг эзэмшдэг байсан бөгөөд шинэ байрандаа 2021 онд нүүж орсон тул хуучин байраа шилжүүлэн өгөх хүсэлт гаргасан бөгөөд ийнхүү шилжүүлснээр Цагдаагийн газрын ажлын байрны нөхцөл сайжирна.

-Дорнод аймгийн Тагнуулын газрын хуучин барилгыг тус аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газарт шилжүүлэн авч ашиглах санал гаргасан.

-Дорнод аймагт хүүхдийн тоо нэмэгдэж сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байгаа тул Хүүхдийн хөгжлийн төвийн барилгыг шинээр барих, өргөтгөх шаардлагатай болсон байна.

-Мөн Замын-Үүдийн Дулааны станц шинээр ашиглалтад орсноор тус сумын төвийн халаалтыг хангаж байсан зуухнууд ашиглалтгүй болсон байсан. Гэтэл зарим алслагдсан аймаг, сумын төвд ийм төрлийн халаалтын зуухыг шинэчлэх шаардлагатай байсан тул шилжүүлэн өгч, ашиглуулах санал гаргасан. Үүнд Хөвсгөл аймгийн Их-Уул сум, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум, Дорноговь аймгийн Сайншанд сум халаалтын зуухыг шилжүүлэн авах санал гаргасан байдаг.

2.Хот суурины усан хангамж, ариутгах татуургын байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцдаг байгууллагууд аймаг, нийслэлийн өмчид шилжсэн байдаг. Шинээр баригдсан болон, хуучин ашиглаж байсан энэ төрлийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үйлчилгээ, арчилгаа цэвэрлэгээ, зохицуулалт, хэрэглээнээс шалтгаалан орон нутгийн өмчид байлгах нь оновчтой юм. Үүнд:

-Нийслэл дэх Цагдан хорих 461 дүгээр ангийн хөрөнгөд бүртгэлтэй ариутгах татуургын шугам сүлжээ, бохир усны шугам, насос станцыг цогцолбороор нь нийслэлийн өмчид шилжүүлж, мэргэжлийн байгууллага болох Ус сувгийн удирдах газарт ашиглалт, үйлчилгээг хариуцуулах;

-Хилийн цэргийн 0288 дугаар анги нь нийслэлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхоны ус дулаан дамжуулах төвийг хариуцан ажиллаж байсан боловч үнэ тарифыг зохицуулалт, ашиглалт үйлчилгээ, засварын асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн байгууллагад хариуцуулах нь оновчтой байсан тул шилжүүлэх санал гаргасан;

3.Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор нийтийн эзэмшилд зориулан улсын төсөв, төрийн өмчит компаниас санхүүжүүлэн барьсан хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит байгууллагад хариуцуулах шаардлагын дагуу нь Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК-ийн барьж байгуулсан гэрэлтүүлгийн системийг Дархан- Уул аймгийн өмчид шилжүүлэх нь зүйтэй байна.

4.Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах Түр хамгаалах байрыг бий болгох зорилгоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын эзэмшилд байгаа 1 давхар барилгыг (564 м.кв газартай) Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст эзэмшүүлэхээр шилжүүлэх шаардлагатай байна.

5.Нийгмийн эрүүл мэндийн түргэн тусламж үйлчилгээ, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, сумдын Эрүүл мэндийн байгууллагад төрийн өмчөөс эд хөрөнгө шилжүүлэх шаардлагын дагуу Баян-Өлгий аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв, Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв, Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв, Завхан аймгийн Сонгино сумын Эрүүл мэндийн төв, Төв аймгийн Батширээт сумын Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн нийт 9 автомашиныг шилжүүлэх шаардлагатай байна.

6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан цагдаа, эрүүл мэнд, хот тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчийн байгууллага болон алслагдсан сумдын төрийн үйлчилгээнд автомашин дутагдалтай байна.

Шинээр автомашин худалдан авах нь эдийн засаг хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд хүндрэлтэй тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинаас орон нутгийн хэрэгцээнд зориулан шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн.

Автомашин шилжүүлэн авах хүсэлтийг ихэнх аймаг, сумдаас ирүүлсэн бөгөөд татан төвлөрүүлсэн нийт 20 автомашиныг аймгийн өмчлөлд шилжүүлэх нь зүйтэй болно.

7.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан шилжин ажиллах улсын байцаагчдыг ашиглаж байгаа тавилга эд хогшил, хөдлөх хөрөнгөтэй нь шилжүүлж, ажиллах хэвийн нөхцөлөөр хангах шаардлага гарсан. Иймд аймгийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эзэмшилд байсан төрийн өмчийн хөрөнгөөс аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар зэрэг байгууллагад шилжүүлэх хөрөнгийг Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгалаа.

Хэдийгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал орон нутгийн өмчийн өмчлөгч байх эрхтэй боловч төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэхдээ зөвхөн аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлсэн байдаг.

Сум, дүүргийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх нь олон өмчлөгчийг бий болгож, орон нутгийн өмчийн бодлого, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад төрийн нэгдсэн хяналт тавихад хүндрэл учруулах тул 360 гаруй сум, 9 дүүргийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх нь оновчгүй гэж үзлээ.

Иймд орон нутгийн нийгэм, эдийн засагт түлхэц болох, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн зохистой зохицуулалт хийх замаар илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, шинээр хөрөнгө худалдаж авахад зарцуулах төсвийн хөрөнгийг хэмнэх, орон нутагт хэрэгцээтэй байгаа хөрөнгийн дэмжлэг үзүүлэх зэрэг дээрх хууль зүйн болон практик шаардлагын дагуу “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төрийн өмчөөс орон нутгийн өмчид хөрөнгө шилжүүлэх зохицуулалтыг тусгах бөгөөд уг тогтоолын төсөл нь төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн байршил, хөрөнгө тус бүрийн үнийн дүнгийн мэдээллийг агуулсан 1 хавсралттай байх болно.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засгийн эерэг үр дүн бий болно гэж үзэж байна:

-тухайн шилжүүлсэн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирна;

-Орон нутгийн өмчит байгууллага ажлын байртай болсноор шинээр барилга барих, автомашин худалдан авахад зарцуулах улсын болон орон нутгийн төсөв хэмнэгдэнэ;

-шилжүүлж авсан хөрөнгийн алслагдмал сум, суурин газарт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна;

-төрийн өмчийн эд хөрөнгийн оновчтой зохицуулалтыг бий болгоно.

Мөн эдгээр хөрөнгөтэй дүйцэхүйц хөрөнгийг улсын орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн бий болгох нь зардал их шаардагдах тул орон нутагт зориулалтаар нь шууд болон засаж сэлбэн ашиглах боломжийг бүрдүүлж, эдийн засгийн хэмнэлт гаргах юм.

Барилга байгууламж (нийтийн эзэмшлийн болон инженерийн шугам сүлжээ)-ийг тухайн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн өмчит байгууллагад хариуцуулан эзэмшүүлснээр данс бүртгэл хөтлөх, ашиглалт үйлчилгээнд хяналт тавих, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэхэд дэмжлэг үзүүлэх давуу талтай юм.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр шинээр байгууллага байгуулах, эсхүл байгууллага дотор шинээр нэгж, алба бий болгох шаардлага үүсэхгүй бөгөөд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмэх зэрэг эдийн засгийн нэмэлт зардал шаардахгүй болно.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан бусад хөрөнгийн хувьд орон нутгийн өмчид шилжсэнээр ашиглалтын зардал нэмэгдэхгүй.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд орон нутагт ажиллах томилолтын зардлыг тооцон үзэхэд 18.2 сая төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо байна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүний хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

ТАНИЛЦУУЛГА

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад Улсын Их Хурал төрийн өмчийн талаар “төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах” бүрэн эрхтэй гэж заасан.

Нэг.Тогтоолын төсөл боловсруулсан зорилго, ач холбогдол

Төрийн өмчид байгаа илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг хэрэгцээ шаардлагатай байгаа орон нутагт шилжүүлэх хөрөнгийн зохицуулалт хийх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж, төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлснээр орон нутаг дахь зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах төдийгүй аймаг, нийслэлийн эдийн засагт багагүй нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Хоёр.Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг зөвхөн Улсын Их Хурлын тогтоолоор шийдвэрлэдэг хуулийн зохицуулалттай болохыг дээр дурдсан билээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн агентлаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төрийн өмчийн эд хөрөнгийн улсын анхны үзлэг, тооллогыг 1997 онд улс орон даяар зохион байгуулж, улмаар 1999 онд аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх 229.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн жагсаалтыг УИХ-ын 29 дүгээр тогтоолоор анх удаа батлуулснаар орон нутгийн өмч бий болсон юм.

Түүнээс хойш Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ноос “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын 2001 оны 91, 2002 оны 84, 93, 2004 оны 18, 2007 оны 37, 2009 оны 90, 2010 оны 73 дугаар тогтоол, 2018 оны 61 дугаар тогтоолыг тус тус батлуулж, тухай бүр хэрэгжүүлсэн юм. Энэ хугацаанд Улсын Их Хурлын тогтоолоор нийт 9 удаа төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлсэн байна.

1. УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор анх удаа нийт 229.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг аймаг, нийслэлийн өмчид шилжүүлсэн.

2. УИХ-ын 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид (15 аймаг, нийслэлд) нийт 4,965,878.18 мянган төгрөгийн хөрөнгө (Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар (Зооноз)-ын хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж)-ийг шилжүүлсэн бөгөөд эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн данс бүртгэлд тусган ашиглах, худалдан борлуулах зэргээр шийдвэрлэсэн байдаг.

3. УИХ-ын 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор Хэнтий аймгийн өмчид “Чандгана” ХК-ийг шилжүүлсэн байна.

4. УИХ-ын 2002 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 93 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (15 аймаг, нийслэлд) нийт 3,847,428.19 мянган төгрөгийн барилга, байгууламжийг шилжүүлсэн бөгөөд эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн данс бүртгэлд тусган усан хангамж, цэцэрлэг яслийн болон бусад зориулалтаар ашигласан байна.

5. УИХ-ын 2004 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (21 аймаг, нийслэлд) нийт 7,746,059.90 мянган төгрөгийн Өрхийн эмнэлгийн барилга, байгууламж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж болон багийн эмчийн мотоцикл зэрэг хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд эдгээр хөрөнгийг орон нутгийн иргэдэд эмнэлгийг үйлчилгээг цаг алдалгүй хүргэхэд ашиглаж байна. Өрхийн эмнэлгийн хөрөнгө нь орон нутгийн өмчид бүртгэлтэй байна.

6. УИХ-ын 2007 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 37 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (8 аймаг, нийслэлд) нийт 1,852,158.32 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн бөгөөд тэдгээрийг холбогдох орон нутгийн өмчит байгууллагын данс бүртгэлд тусган зориулалтын дагуу ашиглаж байна.

7. УИХ-ын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид (9 аймагт) нийт 917,849.73 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн бөгөөд эдгээр барилга байгууламжийг төрийн үйлчилгээ, сум, багийн үйл ажиллагаанд орон нутгийн өмчит байгууллагууд ашиглаж байна.

8. УИХ-ын 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 73 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (2 аймагт) нийт 1,262,510.8 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн бөгөөд эдгээр барилга байгууламжийг орон нутгийн өмчит байгууллагууд ашиглаж байна.

9. УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид (21 аймаг, нийслэлд) нийт 28,136,741.71 мянган төгрөгийн барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд орон нутгийн өмчит байгууллагууд ашиглаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнгийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Засгийн газрын тогтоолыг батлан хэрэгжүүлж байна.

Тооллогын дүнгээр гарсан дүгнэлт, зөвлөмжид төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр тусгасныг харгалзан Улсын Их Хурлын "Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" тогтоолын төслийг боловсруулсан. (Тооллогын дүнг хавсаргав.)

Гурав. Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтад холбогдох байгууллагын хүсэлтээр хэрэгцээ, шаардлагыг нь харгалзан төрийн өмчөөс орон нутгийн өмчид дараах эд хөрөнгийг шилжүүлэхээр тусгалаа:

1. Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар төрийн зарим байгууллага, албан газар, төрийн өмчит компани шинээр барилга байгууламж барьж ашиглалтад оруулснаас хуучин барилга, хөрөнгийг ашиглахгүй болж байна. Нөгөө талаас төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, шат дамжлагагүй хүргэх, орон нутагт зайлшгүй хэрэгцээ шаардлагыг төсвийн хөрөнгөөр нөхөх, бий болгох боломжгүй байна.

Дорнод аймгийн Прокурорын газар тус аймгийн Цагдаагийн газрын байрны 4 дүгээр давхарыг эзэмшдэг байсан бөгөөд шинэ байрандаа 2021 онд нүүж орсон тул хуучин байраа шилжүүлэн өгөх хүсэлт гаргасан. Ийнхүү шилжүүлснээр Цагдаагийн газрын ажлын байрны нөхцөл сайжирна.

Дорнод аймгийн Тагнуулын газрын хуучин барилгыг тус аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газарт шилжүүлэн авч ашиглах санал гаргасан.

Дорнод аймагт хүүхдийн тоо нэмэгдэж сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байгаа тул Хүүхдийн хөгжлийн төвийн барилгыг шинээр барих, өргөтгөх шаардлагатай байгаа.

Мөн Замын-Үүдийн Дулааны станц шинээр ашиглалтад орсноор тус сумын төвийн халаалтыг хангаж байсан зуухнууд ашиглалтгүй болсон байсан. Гэтэл зарим алслагдсан аймаг, сумын төвд ийм төрлийн халаалтын зуухыг шинэчлэх шаардлагатай байсан тул шилжүүлэн өгч, ашиглуулах санал гаргасан. Үүнд Хөвсгөл аймгийн Их-Уул сум, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум, Дорноговь аймгийн Сайншанд сум халаалтын зуухыг шилжүүлэн авах санал гаргасан тул УИХ-ын тогтоолын төсөлд хамрууллаа.

2. Хот суурины усан хангамж, ариутгах татуургын байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцдаг байгууллагууд аймаг, нийслэлийн өмчид шилжсэн байдаг. Шинээр баригдсан болон, хуучин ашиглаж байсан энэ төрлийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үйлчилгээ, арчилгаа цэвэрлэгээ, зохицуулалт, хэрэглээнээс шалтгаалан орон нутгийн өмчид байлгах нь оновчтой юм. Энэ шаардлагаар дараах хөрөнгийн асуудлыг УИХ-ын тогтоолын төсөлд хамруулав.

2.1. Нийслэл дэх Цагдан хорих 461 дүгээр ангийн хөрөнгөд бүртгэлтэй ариутгах татуургын шугам сүлжээ, бохир усны шугам, насос станцыг цогцолбороор нь нийслэлийн өмчид шилжүүлж, мэргэжлийн байгууллага болох Ус сувгийн удирдах газарт ашиглалт, үйлчилгээг хариуцуулах;

2.2. Хилийн цэргийн 0288 дугаар анги нь БЗД-ийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхоны ус дулаан дамжуулах төвийг хариуцан ажиллаж байсан боловч үнэ тарифыг зохицуулалт, ашиглалт үйлчилгээ, засварын асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн байгууллагад хариуцуулах нь оновчтой байсан тул шилжүүлэх санал гаргасан;

3. Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор нийтийн эзэмшилд зориулан улсын төсөв, төрийн өмчит компаниас санхүүжүүлэн барьсан хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит байгууллага нь хариуцах шаардлага гарсан. Үүнд, Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК-ийн барьж байгуулсан гэрэлтүүлгийн системийг Дархан- Уул аймгийн өмчид шилжүүлэх;

4. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах Түр хамгаалах байрыг бий болгоход шаардлагатай байгаа барилгын нийслэлийн өмчид шилжүүлэх шаардлага гарсан

Иймд Засгийн газрын агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын эзэмшилд байгаа 1 давхар барилгыг (564 м.кв газартай) Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст эзэмшүүлэхээр шилжүүлэх;

5. Нийгмийн эрүүл мэндийн түргэн тусламж үйлчилгээ, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг сумдын Эрүүл мэндийн байгууллагад төрийн өмчөөс эд хөрөнгө шилжүүлэх шаардлага гарч байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв, Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв, Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв, Завхан аймгийн Сонгино сумын Эрүүл мэндийн төв, Төв аймгийн Батширээт сумын Эрүүл мэндийн төвд эмгэлгийн зориулалттай, түргэн тусламжийн 9 автомашиныг шилжүүлэх;

6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан цагдаагийн, эрүүл мэндийн, хот тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчийн байгууллага болон алслагдсан сумдын төрийн үйлчилгээнд автомашин дутагдалтай байна. Шинээр автомашин худалдан авах нь эдийн засаг хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд хүндрэлтэй тул Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинаас орнон нутгийн хэрэгцээнд зориулан шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн.

Автомашин шилжүүлэн авах хүсэлтийг бараг бүх аймаг, сумдаас ирүүлсэн боловч зөвхөн татан төвлөрүүлсэн нийт 20 автомашиныг аймгийн өмчлөлд шилжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд тусгасан.

7. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (21 аймаг, нийслэл дэх салбар нэгж)-ыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох төрийн байгууллагад шилжүүлсэнтэй

холбогдуулан шилжин ажиллаж буй төрийн албан хаагчдын ашиглаж буй тавилга эд хогшил, хөдлөх хөрөнгийг холбогдох орон нутгийн өмчит байгууллагад шилжүүлж, улсын байцаагчдыг ажиллах хэвийн нөхцөлөөр хангах шаардлага гарсан. Иймд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар зэрэг байгууллагад шилжүүлэх хөрөнгийг УИХ-ын тогтоолын төсөлд хамрууллаа.

Гурав. Тогтоолын төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахтай холбогдуулан орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх санал хүсэлтийг нэг бүрчлэн судалж, хөрөнгө эзэмшиж буй байгууллагын саналыг албан ёсоор авсан. Хөрөнгө эзэмшиж буй байгууллага нь шилжүүлэхийг дэмжсэн хөрөнгийг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхээр тогтоолын төсөлд тусгасан болно.

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөлд тусгагдсан хөрөнгийн талаар танилцуулгад дэлгэрэнгүй тусгав.

Дөрөв. Тогтоолын төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг (аймаг, нийслэлийн Орон нутгийн өмчийн газрын дунд) 2022 онд зохион байгуулсан.

Тав. Гадаад орны туршлага

АНУ, ОХУ зэрэг ихэвчлэн “холбооны” төрийн байгууламжтай улс төрийн, орон нутгийн өмчтэй байдаг. Мөн Хятад, Солонгос зэрэг зарим нэгдмэл улс төрийн, орон нутгийн өмчтэй байх тохиолдол бий. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тухайн асуудлыг зохицуулсан хуулиар, тийм хуульгүй улсын хувьд Иргэний хууль, Компанийн хууль, холбогдох төрийн байгууллагын шийдвэрээр тус тус зохицуулдаг байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар:.....

Улаанбаатар
хот

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

ГАРЫН ҮСЭГ

Улсын Их Хурлын 2023 оны ... дүгээр сарын
.....-ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх
эд хөрөнгийн жагсаалт

(төгрөгөөр)

1. Архангай аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн байршил, (эзэмшигч байгууллага)	Шилжүүлэх хөрөнгө	Хөрөнгийн нийт (балансын) үнэ	Хөрөнгө хүлээн авах байгууллагын нэр
1	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө- 27 ширхэг	19,395,638.65	Архангай аймгийн Засаг даргын Тамгын газар
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө- 18 ширхэг	44,467,582.81	Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-5 ширхэг	2,318,200.00	Архангай аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-9 ширхэг	3,758,355.00	Архангай аймгийн Эрүүл мэндийн газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-1 ширхэг	16,999,950.00	Архангай аймгийн Цагдаагийн газар
6	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-21 ширхэг	10,276,016.00	Архангай аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
	дүн		97,215,742.46	

2. Баян-Өлгий аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Суудлын автомашин УАЗ фургон, 0914 УБГ	37,900,000.00	Баян-Өлгий аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төв
2	Барилга хөгжлийн төв ТӨҮГ	Суудлын автомашин Прадо 150, 7288 УНУ	62,665,141.79	Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын тамгын газар
3	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	Суудлын автомашин Мицубуши Пажеро, 6342 УНН	48,495,951.40	Баян-Өлгий аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газар
	дүн		149,061,093.19	

3. Баянхонгор аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-52 ширхэг	29,009,055.00	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-24 ширхэг	35,528,300.00	Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-4 ширхэг	2,121,300.00	Баянхонгор аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-27 ширхэг	18,606,300.00	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-2 ширхэг	2,183,000.00	Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
	Дүн		87,447,955.00	

4. Булган аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2	Суудлын автомашин УАЗ Фургон УНЧ 70-31	36,755,000.00	Булган аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төв
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-16 ширхэг	6,824,375.70	Булган аймгийн Эрүүл мэндийн газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-4 ширхэг	1,804,870.00	Булган аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-19 ширхэг	6,876,324.64	Булган аймгийн Аймгийн Засаг даргын Тамгын газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-17 ширхэг	26,192,829.02	Булган аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар
6	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-32 ширхэг	18,882,250.68	Булган аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
	Дүн		97,335,650.04	

5. Говь-Алтай аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Суудлын автомашин УАЗ фургон, 2754 УАН	37,900,000.00	Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв
2	Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ	Халаалтын зуух	43,923,000.00	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын "Эрчим хүч" ОНӨААТҮГ
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-32 ширхэг	15,955,556.00	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-62 ширхэг	48,532,520.55	Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-6 ширхэг	3,087,500.00	Говь-Алтай аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
6	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-23 ширхэг	13,647,433.33	Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар

7	"Дулааны 2-р станц" ТӨХК	Суудлын автомашин Тоёота ланд круйзер прадо,9127 УБА	30,123,631.00	Говь-Алтай аймгийн Бугат сум Засаг даргын тамгын газар
8	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Суудлын автомашин УАЗ-469,01-03 УАМ	35,000,000.00	Говь-Алтай аймгийн Алтай сумын Эрүүл мэндийн төв
	Дүн		228,169,640.88	

6. Говь-Сүмбэр аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-11 ширхэг	22,298,214.10	Говь-Сүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-5 ширхэг	2,577,338.40	Говь-Сүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-5 ширхэг	3,961,125.40	Говь-Сүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-24 ширхэг	10,114,318.10	Говь-Сүмбэр аймгийн Эрүүл мэндийн газар
	Дүн		38,950,996.00	

7. Дархан-Уул аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК	Гудамжны гэрэлтүүлэг (2 нэрийн 114 ширхэг)	28,429,805.82	Дархан-Уул аймгийн Хот тохижилт үйлчилгээний газар
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-14 ширхэг	64,537,961.25	Дархан-Уул аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-36 ширхэг	12,537,620.62	Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-14 ширхэг	11,656,331.70	Дархан-Уул аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-24 ширхэг	13,480,092.68	Дархан-Уул аймгийн Аймгийн Засаг даргын Тамын газар
6	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-28 ширхэг	31,767,226.00	Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
7	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-726 ширхэг	15,671,210.00	Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргын тамгын газар
8	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Суудлын автомашин Ланд круйзер 200 УБГ 09-66	251,542,950.00	Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар
	Дүн		429,623,198.07	

8. Дорнод аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Дорнод аймгийн Прокурорын газар	Конторын барилгын 4 дүгээр давхар	3,567,712.56	Дорнод аймгийн Цагдаагийн газар
2	Тагнуулын ерөнхий газар	Хуучин барилга	289,566,916.43	Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-27 ширхэг	28,942,390.00	Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-30 ширхэг	39,171,011.97	Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-11 ширхэг	74,989,720.78	Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
6	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-37 ширхэг	28,310,565.70	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар
7	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-11 ширхэг	14,309,100.00	Дорнод аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
8	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-1 ширхэг	200,000.00	Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар
9	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	Суудлын автомашин Ниссан теана, 0482 УБЗ	22,357,530.00	Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын тамгын газар
10	Шинжлэх ухаан технологийн их сургууль	Суудлын автомашин Тоёота Прадо, 52-54 УНЯ	40,000,000.00	Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газар
	Дүн		541,414,947.44	

9. Дундговь аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Суудлын автомашин УАЗ фургон, 0297 УАМ	31,500,000.00	Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-41 ширхэг	12,392,963.84	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-7 ширхэг	23,869,957.04	Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-5 ширхэг	2,540,328.04	Дундговь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-13 ширхэг	8,635,800.00	Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар
6	Хими хими технологийн хүрээлэн	Суудлын автомашин Хьюндай Азера, 0213 УНӨ	10,000,000.00	Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газар
7	Онцгой байдлын ерөнхий газар	Суудлын автомашин Соната-7, 6214 УНА	21,000,000.00	Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар
	Дүн		109,939,048.92	

10. Дорноговь аймгийн өмчид шилжүүлэх хөрөнгө

1	Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ	Халаалтын зуух	138,164,946.02	Чандмань Илч ХХК
2	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-6 ширхэг	29,697,641.98	Дорноговь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-18 ширхэг	10,860,452.87	Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар
4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-9 ширхэг	24,449,930.00	Дорноговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Тавилга эд хогшил, бусад хөдлөх үндсэн хөрөнгө-15 ширхэг	9,301,846.00	Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар
1.Тогтоолын төслийг зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхэд тавьсан зорилгод хүрэхэд чиглэсэн зохицуулалт тогтоолын төсөлд бүрэн тусгагдсан байна;

2.Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэхдээ аймаг, нийслэлийн нутгийн удирдах байгууллага, орон нутгийн өмчийн газар болон эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй бусад байгууллагын төлөөллийг оролцуулсан санал авсан бөгөөд орон нутгийн өмчид хүлээн авах асуудлыг дэмжиж, хөрөнгийг хүлээн авч ашиглахад бэлэн байгаагаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан ёсоор ирүүлсэн;

3.Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа шалгуур үзүүлэлтээр Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтад аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэхээр тусгасан төрийн өмчийн эд хөрөнгийн одоогийн эзэмшигч байгууллагаас саналыг албан бичгээр авч үнэлсэн.

**“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээгээр тогтоолын төсөл батлагдсан нөхцөлд зорилгодоо хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой, орон нутгийн өмчид хөрөнгө хүлээн авах байгууллага хүлээн зөвшөөрсөн дүгнэлт гарсан байна.

Иймд “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэвээр үлдээхийг зөвлөж байна.

_____ооо_____

**“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДАЛ**
(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Ажил- лах хүний тоо	Ажил- лах хоног	Томилолтын зардал	Замын зардал (аймаг хоорондын унаа)		Нийт зардал
					онгоц	автомашин /шатахуун/	
Архангай, Өвөрхангай, Баянхонгор							
1	Баянхонгор	2	2	472,000.00		696,390.00	1,168,390.00
2	Архангай	2	2	472,000.00			472,000.00
3	Өвөрхангай /Хархорин/	2	3	708,000.00			708,000.00
	дүн		7	1,652,000.00	-	696,390.00	2,348,390.00
Дархан, Сэлэнгэ							
4	Дархан-Уул	2	2	568,000.00		93,825.00	661,825.00
5	Сэлэнгэ, Зүүнхараа	2	3	708,000.00		189,735.00	897,735.00
	дүн		5	1,276,000.00		283,560.00	1,559,560.00
Булган, Хөвсгөл, Орхон							
6	Хөвсгөл	2	2	472,000.00		651,771.00	1,123,771.00
7	Орхон	2	2	568,000.00			568,000.00
8	Булган	2	2	472,000.00			472,000.00
	дүн		6	1,512,000.00	-	651,771.00	2,163,771.00
Увс, Ховд, Баян-Өлгий							
9	Баян-Өлгий	2	2	472,000.00	892,300.00		1,364,300.00
10	Увс	2	2	472,000.00		266,463.00	738,463.00
11	Ховд	2	2	472,000.00	880,000.00		1,352,000.00
	дүн		6	472,000.00	1,772,300.00	-	3,454,763.00
Өмнөговь, Дундговь, Төв							
12	Өмнөговь	2	2	472,000.00		523,752.00	995,752.00
13	Дундговь	2	2	472,000.00			472,000.00
14	Төв	2	2	472,000.00			472,000.00
	дүн		6	1,416,000.00	-	523,752.00	1,939,752.00
Завхан, Говь-Алтай							
15	Говь-Алтай	2	2	472,000.00	1,182,400.00	395,611.00	2,050,011.00
16	Завхан (Тосонцэнгэл)	2	3	708,000.00		396,874.00	1,104,874.00
	дүн		5	1,180,000.00	1,182,400.00	792,485.00	3,154,885.00
Дорнод, Хэнтий, Сүхбаатар							
17	Дорнод	2	2	472,000.00			472,000.00
18	Хэнтий	2	2	472,000.00		467,040.00	939,040.00
19	Сүхбаатар	2	2	472,000.00			472,000.00
	дүн		6	1,416,000.00	-	467,040.00	1,883,040.00
Дорноговь, Говь-Сүмбэр, Замын-Үүд							
20	Говь-Сүмбэр	2	2	472,000.00		467,040.00	939,040.00
21	Дорноговь	2	2	472,000.00			472,000.00
22	Замын-Үүд	2	2	256,000.00			256,000.00
	дүн		6	1,200,000.00		467,040.00	1,667,040.00
	Нийт зардал						18,171,201.00

"Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон 21 аймаг, суманд төрийн албан хаагчийн томилолтоор ажиллах нийт 18,171,201.00 (арван найман сая нэг зуун далан нэгэн мянга хоёр зуун нэг) төгрөгийн зардал төрийн байгууллагын төсвөөс зарцуулах тооцоо гарлаа.

“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдаж нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг зөвшөөрснөөр 1992 оны Иргэний хуульд нийтийн өмчийн төрөл нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байх бөгөөд төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг өмчлөгч байхаар заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад бүх ард түмнийг төлөөлж төрийн өмчийн өмчлөгч нь Улсын Их Хурал, 77 дугаар зүйлийн 77.1-д тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг өмчлөгч нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус байхаар заасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн агентлаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төрийн өмчийн эд хөрөнгийн улсын анхны үзлэг, тооллогыг улс орон даяар 1997 онд зохион байгуулж, улмаар анх удаа 1999 онд УИХ-ын 29 дүгээр тогтоолоор аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх 229.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн жагсаалтыг батлуулснаар орон нутгийн өмч бий болсон юм.

Түүнээс хойш Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ноос төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай тогтоолын төслийг боловсруулан УИХ-ын 2001 оны 91, 2002 оны 84, 93, 2004 оны 18, 2007 оны 37, 2009 оны 90, 2010 оны 73, 2018 оны 61 дүгээр тогтоолыг батлуулж хэрэгжүүлсэн юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогын дүнтэй хамтатган төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай асуудал тавигдсан юм.

Нэг.Тавигдаж буй асуудал, түүнд хийсэн дүн шинжилгээ, асуудлын мөн чанар, цар хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлд орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах нэг хэлбэр нь төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж шилжүүлэх гэж заасныг үндэслэн орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авах асуудлыг хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдох байгууллагаас байнга ирүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллага, бусад байгууллагаас төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авахаар ирүүлсэн хүсэлтийг судалж үзэхэд орон нутагт дараах асуудал үүссэн байна:

-Аймаг, нийслэлд төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэхэд шаардагдах хөрөнгө дутагдалтай, хөрөнгө олж авах санхүүгийн эх үүсвэр хангалтгүй;

-Хот суурины усан хангамж, ариутгах татуургын мэргэжлийн байгууллагууд орон нутгийн өмчид байдаг.

21 аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нар болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс хөрөнгө шилжүүлэн авах хүсэлтийг гаргаж

тухайн хөрөнгийг эзэмшиж буй төсвийн байгууллага, албан газар, төрийн өмчит компанид хандсан байна.

Төрөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авах хүсэлтийг нэгтгэн жагсаалт, төсөл боловсруулж, шалтгаан нөхцөлийг асуудлыг шийдвэрлүүлэх зорилго, шаардлага, цаашдын ашиглалтын ижил төстэй байдлаар нь багцлан дүгнэв. Аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авах асуудлыг дараах хэрэгцээ, шаардлагын үүднээс тавьсан байна:

1. Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар төрийн зарим байгууллага, албан газар, төрийн өмчит компани шинээр барилга байгууламж барьж ашиглалтад оруулснаас хуучин барилга, хөрөнгийг ашиглахгүй болж байна. Нөгөө талаас төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, шат дамжлагагүй хүргэх, орон нутагт зайлшгүй хэрэгцээ шаардлагыг төсвийн хөрөнгөөр нөхөх, бий болгох боломжгүй байна.

Дорнод аймгийн Прокурорын газар тус аймгийн Цагдаагийн газрын байрны 4 дүгээр давхарыг эзэмшдэг байсан бөгөөд шинэ байрандаа 2021 онд нүүж орсон тул хуучин байраа шилжүүлэн өгөх хүсэлт гаргасан. Ийнхүү шилжүүлснээр Цагдаагийн газрын ажлын байрны нөхцөл сайжирна.

Дорнод аймгийн Тагнуулын газрын хуучин барилгыг тус аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газарт шилжүүлэн авч ашиглах санал гаргасан.

Дорнод аймагт хүүхдийн тоо нэмэгдэж сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байгаа тул Хүүхдийн хөгжлийн төвийн барилгыг шинээр барих, өргөтгөх шаардлагатай байгаа.

Мөн Замын-Үүдийн Дулааны станц шинээр ашиглалтад орсноор тус сумын төвийн халаалтыг хангаж байсан зуухнууд ашиглалтгүй болсон байсан. Гэтэл зарим алслагдсан аймаг, сумын төвд ийм төрлийн халаалтын зуухыг шинэчлэх шаардлагатай байсан тул шилжүүлэн өгч, ашиглуулах санал гаргасан. Үүнд Хөвсгөл аймгийн Их-Уул сум, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум, Дорноговь аймгийн Сайншанд сум халаалтын зуухыг шилжүүлэн авах санал гаргасан тул УИХ-ын тогтоолын төсөлд хамрууллаа.

2. Хот суурины усан хангамж, ариутгах татуургын байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцдаг байгууллагууд аймаг, нийслэлийн өмчид шилжсэн байдаг. Шинээр баригдсан болон, хуучин ашиглаж байсан энэ төрлийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үйлчилгээ, арчилгаа цэвэрлэгээ, зохицуулалт, хэрэглээнээс шалтгаалан орон нутгийн өмчид байлгах нь оновчтой юм. Энэ шаардлагаар дараах хөрөнгийн асуудлыг УИХ-ын тогтоолын төсөлд хамруулав.

2.1. Нийслэл дэх Цагдан хорих 461 дүгээр ангийн хөрөнгөд бүртгэлтэй ариутгах татуургын шугам сүлжээ, бохир усны шугам, насос станцыг цогцолбороор нь нийслэлийн өмчид шилжүүлж, мэргэжлийн байгууллага болох Ус сувгийн удирдах газарт ашиглалт, үйлчилгээг хариуцуулах;

2.2. Хилийн цэргийн 0288 дугаар анги нь БЗД-ийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхоны ус дулаан дамжуулах төвийг хариуцан ажиллаж байсан боловч үнэ тарифыг зохицуулалт, ашиглалт үйлчилгээ, засварын асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн байгууллагад хариуцуулах нь оновчтой байсан тул шилжүүлэх санал гаргасан;

3. Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор нийтийн эзэмшилд зориулан улсын төсөв, төрийн өмчит компаниас санхүүжүүлэн барьсан хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит байгууллага нь хариуцах шаардлага гарсан. Үүнд,

Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК-ийн барьж байгуулсан гэрэлтүүлгийн системийг Дархан- Уул аймгийн өмчид шилжүүлэх;

4. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах Түр хамгаалах байрыг бий болгоход шаардлагатай байгаа барилгын нийслэлийн өмчид шилжүүлэх шаардлага гарсан

Иймд Засгийн газрын агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын эзэмшилд байгаа 1 давхар барилгыг (564 м.кв газартай) Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст эзэмшүүлэхээр шилжүүлэх;

5. Нийгмийн эрүүл мэндийн түргэн тусламж үйлчилгээ, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг сумдын Эрүүл мэндийн байгууллагад төрийн өмчөөс эд хөрөнгө шилжүүлэх шаардлага гарч байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв, Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв, Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв, Завхан аймгийн Сонгино сумын Эрүүл мэндийн төв, Төв аймгийн Батширээт, Увс аймгийн Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвд нийт 9 автомашиныг шилжүүлэх;

6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан цагдаагийн, эрүүл мэндийн, хот тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчийн байгууллага болон алслагдсан сумдын төрийн үйлчилгээнд автомашин дутагдалтай байна. Шинээр автомашин худалдан авах нь эдийн засаг хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд хүндрэлтэй тул Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинаас орнон нутгийн хэрэгцээнд зориулан шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн. Автомашин шилжүүлэн авах хүсэлтийг бараг бүх аймаг, сумдаас ирүүлсэн боловч зөвхөн татан төвлөрүүлсэн нийт 20 автомашиныг аймгийн өмчлөлд шилжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд тусгасан.

7. Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгаж, чиг үүргийн холбогдох төрийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан шилжин ажиллаж буй төрийн албан хаагчдын ашиглаж буй тавилга эд хогшил, хөдлөх хөрөнгийг холбогдох орон нутгийн өмчит байгууллагад шилжүүлж, улсын байцаагчдыг ажиллах хэвийн нөхцөлөөр хангах шаардлага гарсан. Иймд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эзэмшилд байсан төрийн өмчийн хөрөнгөөс аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар зэрэг байгууллагад шилжүүлэх хөрөнгийг УИХ-ын тогтоолын төсөлд хамрууллаа.

Ийнхүү УИХ-ын тогтоолоор 21 аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын өмчид нийт 4,613,215,438.2 төгрөгийн хөрөнгийг шилжүүлэхээр хөрөнгийн жагсаалтыг байршил, үнийн дүнгийн хамт бэлтгэлээ.

Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авахаар аймаг, орон нутгаас ирсэн хүсэлтийг судалж үзэхэд дараах шалтгаан нөхцөл харагдаж байна:

- Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай байгаа өнөөгийн нөхцөлд шинээр хөрөнгө бий болгох нь зардал их, хугацаа шаарддаг;

- Орон нутгийн зарим байгууллагын байр, талбай, эд хөрөнгийн хүрэлцээ дутмаг;

- Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүрээнд орон нутгийн өмчийн газар хяналт тавих боломж бүрдүүлэх.

Хөрөнгийг орон нутагт шилжүүлснээр гарах үр дүнг тухайн хөрөнгийг ашиглах зардалтай харьцуулах нь ач холбогдол багатай бөгөөд орон нутгийн төсвөөс цаашид ашиглалтын зардлыг хариуцах боломжтой гэдгээ илэрхийлсэн болно.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр орон нутгийн зарим байгууллагын байр талбай, хөрөнгийн хүрэлцээ дутмаг болон өмнө дурдсан бусад асуудлыг дараах байдлаар шийдвэрлэх зорилго тавьж байна:

-тухайн шилжүүлсэн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирна;

--Орон нутгийн өмчит байгууллага ажлын байртай болсноор шинээр барилга барих, автомашин худалдан авахад зарцуулах улсын болон орон нутгийн төсөв хэмнэгдэнэ;

-шилжүүлж авсан хөрөнгийн алслагдмал сум, суурин газарт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна.

-төрийн өмчийн эд хөрөнгийн оновчтой зохицуулалтыг бий болгоно.

-орон нутгийн байгууллагад шилжсэн албан хаагчид хэвийн ажиллах нөхцөл бололцоогоор хангагдана.

Мөн эдгээр хөрөнгөтэй дүйцэхүйц хөрөнгийг улсын орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн бий болгох нь зардал их шаардах тул орон нутагт зориулалтаар нь шууд болон засаж сэлбэн ашиглах боломжийг бүрдүүлж, эдийн засгийн хэмнэлт гаргах юм.

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр нутгийн өөрөө удирдах байгууллагын нийгэм, эдийн засгийн чадавхид түлхэц болж, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн зохистой зохицуулалт хийснээр шинээр хөрөнгө худалдаж авахад зарцуулах төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилго тавьж байна.

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулсан судалгаа

“Тэг” хувилбар: Энэ хувилбарыг сонгож Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхгүй орхих боломжтой боловч энэ нь орон нутгийн хөрөнгө, эх үүсвэрийн дутагдлыг нөхөх, хөрөнгийн ашиглалт, бүртгэл хяналтыг сайжруулах, төсвийн хэмнэлт, орон нутгийн нийгэм, эдийн засагт түлхэц үзүүлэх зорилгод хүрэх боломжгүй болно.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбар: Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхгүй тул энэ хувилбар зорилгод хүрэх арга болж чадахгүй юм.

Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх хувилбар: Зах зээлийн механизмаар буюу татвар, хураамжийн бодлого, лиценз зөвшөөрөл болон квот зэргээр хязгаарлалт тогтоох зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь орон нутгийн өмчид үнэ төлбөргүй хөрөнгө оруулалт хийх, төрийн болон орон нутгийн өмчийн зохистой зохицуулалт хийх боломжгүй тул төслийн зорилго биелэгдэхгүй юм.

Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар: Төрөөс орон нутагт шууд мөнгөн дэмжлэгийг үзүүлэх санхүүгийн боломж байхгүй тул энэ хувилбарыг сонгох боломжгүй юм.

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар: Төрөөс гүйцэтгэх тодорхой чиг үүргийг гуравдагч этгээд буюу төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шаардлагагүй тул энэхүү хувилбар нь төслийн хувьд тохиромжгүй юм.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтаар энэхүү төслийг шийдвэр нь зөвхөн УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул захиргааны акт, захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар шийдвэрлэх эрх зүйн боломжгүй юм.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрхэд “төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах” гэж заасан тул Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Дөрөв. Зохицуулалтын хувилбарын үр нөлөө

Энэхүү нөлөөллийг тандан судлахдаа Хүснэгт 1, 2, 3, 4-т дурдсан суурь асуултуудыг ашигласан бөгөөд тэдгээр хүснэгтийг тус тус хавсаргав.

УИХ-ын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн болно. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх нь дотоодын хууль тогтоомжоор зохицуулагддаг бөгөөд олон улсын гэрээгээр зохицуулагдаггүй болно.

Тав. Зохицуулалтын хувилбарыг харьцуулсан дүгнэлт

Зохицуулалтын хувилбараас сонгож болох “Тэг” хувилбар болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын төслийн зорилгод хүрэх байдал,

зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжид нийцсэн байдал, олон нийтийн цахим хэлэлцүүлэг, хүн, байгаль орчинд үзүүлэх нөлөө зэрэг шалгуур үзүүлэлтээр харьцуулан доорх хүснэгтэд харуулав.

Шалгуур үзүүлэлт	“Тэг” хувилбар	Хууль, тогтоомжийн төсөл боловсруулах
Зорилгод хүрэх байдал	<p>Эерэг тал:</p> <p>Сөрөг тал:</p> <p>Хөрөнгө олж авахтай холбоотой зардал хэмнэгдэнэ, орон нутгийн эдийн засагт түлхэц үзүүлэх боломжгүй болсноор асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэхгүй.</p>	<p>Эерэг тал:</p> <p>-тухайн шилжүүлсэн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирна;</p> <p>--Орон нутгийн өмчит байгууллага ажлын байртай болсноор шинээр барилга барих, автомашин худалдан авахад зарцуулах улсын болон орон нутгийн төсөв хэмнэгдэнэ;</p> <p>-шилжүүлж авсан хөрөнгийн алслагдмал сум, суурин газарт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна.</p> <p>-төрийн өмчийн эд хөрөнгийн оновчтой зохицуулалтыг бий болгоно.</p> <p>Сөрөг тал:</p> <p>-Орон нутгийн өмчид шилжсэн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн ашиглалттай холбоотой /цахилгаан, дулаан, ус, газар, үл хөдлөх хөрөнгийн төлбөр, засварын зардал г.м/ зардал гарна.</p> <p>Гэхдээ шинээр хөрөнгө олж авснаас бага зардал гарч зорилгод эерэг нөлөө үзүүлж байна.</p>
Зардал, үр өгөөжийн харьцаа	<p>Эерэг тал: Улсын төсвөөс хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон 18.2 сая төгрөгийн зардал гарахгүй.</p> <p>Сөрөг тал:</p> <p>-Орон нутгийн нийгэм, эдийн засагт үр ашиггүй;</p> <p>-Төрийн өмчийн илүүдэлтэй болон ашиглалтгүй хөрөнгийн өгөөж буурах, үнэгүйдэх;</p> <p>- Автомашин худалдан авах зардал гарна;</p>	<p>Эерэг тал:</p> <p>-Гарах зардлаас илүү орлого олох боломж нэмэгдэж орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдалд эерэг нөлөөлнө;</p> <p>- Орон нутагт хөрөнгийн ашиглалт нэмэгдэж эдийн засагт өгөөж өгнө;</p> <p>-Бүртгэлээр тавих хяналт сайжирч хөрөнгө эзэнгүйдэх, үнэгүйдэх асуудал үүсэхгүй;</p> <p>Сөрөг тал:</p> <p>-УИХ-ын тогтоол батлагдвал хөрөнгө шилжүүлэн хүлээлцэхтэй холбогдон томилолтын зардалд 18.2 сая төгрөг төсвөөс гарна.</p>

	- Хөрөнгө шинээр олж авахад илүү өндөр зардал гарна.	
Хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх	Сөрөг тал: -төрийн өмчөөс үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авах орон нутгийн эрх ашиг биелэгдэхгүйд хүрнэ;	Эерэг тал: Хууль тогтоомжид нийцнэ.
Олон нийтийн цахим хэлэлцүүлэг	Орон нутагт үр дүнгүй хувилбар	Эд хөрөнгө шилжсэнээр орон нутгийн эрх, хууль ёсны сонирхолд нийцэх тул үр дүнтэй хувилбар Хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах үр ашигтай тул тогтоолын төслийг дэмжиж саналаа албан бичгээр ирүүлсэн.
Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Нөлөө байхгүй.	Нөлөө байхгүй.

Зургаа. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

АНУ, ОХУ зэрэг ихэвчлэн "холбооны" төрийн байгууламжтай улс төрийн, орон нутгийн өмчтэй байдаг. Мөн Хятад, Солонгос зэрэг зарим нэгдмэл улс төрийн, орон нутгийн өмчтэй байх тохиолдол бий. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тухайн асуудлыг зохицуулсан хуулиар, тийм хуульгүй улсын хувьд Иргэний хууль, Компанийн хууль, холбогдох төрийн байгууллагын шийдвэрээр тус тус зохицуулдаг байна.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	+ Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	+ Тийм	Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	+ Үгүй	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	+ Үгүй	шаардлагагүй

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Тийм	Үгүй	хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Тийм	+ Үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	+	Тийм	Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Тийм	Үгүй	хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх		Тийм	Үгүй	хамааралгүй

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм + Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм + Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм + Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм + Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм + Үгүй	

	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	+	Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	+	Үгүй	
	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	+	Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	+	Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	+	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	+	Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	+	Үгүй	
	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	+	Тийм	Үгүй	Эд хөрөнгө шилжсэнээр өмчлөх эрх шилжинэ
5.Өмчлөх эрх	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	+	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	+	Үгүй	
	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		Үгүй	Шууд нөлөөгүй боловч дэмжих боломжтой
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		Үгүй	Шууд нөлөөгүй боловч дэмжих боломжтой
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	

	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	+ Тийм	Үгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй эерэгээр
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	+ Тийм	Үгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Төсвийн зардал буурна Үгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	+ Үгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	+ Тийм	Үгүй
11.Олон улсын харилцаа	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	+ Үгүй
	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	+	Тийм	Үгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Тийм	+ Үгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	+	Тийм	Үгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Тийм	+ Үгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	+	Тийм	Үгүй эерэг
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Тийм	+ Үгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Тийм	+ Үгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Тийм	+ Үгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Тийм	+ Үгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Тийм	+ Үгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Тийм	+ Үгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Тийм	+ Үгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Тийм	+ Үгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Тийм	+ Үгүй

мэдээлэл, ёс суртахуун	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй

8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй
8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм + Үгүй	
	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм + Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм + Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм + Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм + Үгүй	
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм + Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй	
4.Усны нөөц	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй	
	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм + Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм + Үгүй	

5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	+	Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	+	Тийм	Үгүй	Зарим барилгын зориулалтыг өөрчлөнө
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	+	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм		Үгүй	хамааралгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм		Үгүй	хамааралгүй

“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай асуудлыг УИХ-ын тогтоолоор батлуулж хэрэгжүүлэх нь хууль тогтоомжид нийцсэн, хамгийн үр дүнтэй хувилбар юм.

Иймд үүссэн асуудлыг шийдвэрлэх шаардлагаар болон Төсвийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутагт цэцэрлэг байгуулах, төрийн зарим байгууллагад дутагдалтай хөрөнгө олгох зорилгод хүрэхийн тулд “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар сонгохыг зөвлөж байна.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг зохицуулалтын бусад хувилбартай хамтатган хэрэгжүүлэх нь үр дүнгүй бөгөөд уг хувилбарыг дангаар нь хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

**ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ
ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ
АЖЛЫН ХЭСЭГТ ОРОХ АЛБАН ТУШААЛТНЫ НЭРС**

№	Овог, нэр	Албан тушаал
1	Д.Амарбаясгалан	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
2	Б.Баасандорж	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
3	Б.Цэнгэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга
4	Ш.Мөнхцэрэн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга
5	Д.Нямдэлгэр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын Засгийн газрын референт
6	Д.Нарангэрэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга